



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 16 өдөр

Дугаар А/795

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай” хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. “Жендэрийн тэгш байдлыг хангах” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулах олон нийтэд чиглэсэн сургалт, сурталчилгаа нөлөөллийн ажлын зардалд 5 190 000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд шаардагдах 5 190 000 төгрөг /таван сая нэг зуун ерөн мянга/-ийг орон нутгийн хөгжлийн сангийн төсөл арга хэмжээний 4.9 -д тусгагдсан “Жендэрийн тэгш байдлыг хангах” хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Даваадорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2021 оны  
12 дугаар сарын 16-ны өдрийн  
А/795 дугаар захирамжийн хавсралт



### ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Давтамж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ	Хөтөлбөрөөс
1	"Жендэрийг тэгшитгэх ирээдүйн эзэд" нэвтрүүлэг	ширхэг	1	1	300,000	300,000	300,000
2	"Хос багана" нэвтрүүлэг	ширхэг	1	1	300,000	300,000	300,000
3	"Та эрүүл бол гэр бүл жаргалтай" нэвтрүүлэг	сар	1	1	300,000	300,000	300,000
4	"Хөвгүүдээ сонсьё" видео контент				300,000	300,000	300,000
5	"Эрүүл иргэн эх орны баялаг" нөлөөллийн ажил	сар	1	1	950,000	950,000	950,000
6	"Гэр бүлийн гишүүн бүр үүрэгтэй" хэлэлцүүлэг, ярилцлага, /романтик дарстай, лаатай болзоо/	сар	1	1	850,000	850,000	850,000
7	Сумдын багийн засаг дарга нарт "Малчдын жендэрийн асуудал" сэдэвт онлайн уулзалтыг хийх /Тараах материал, хичээлийн сэдвийг цаасан болон видео хэлбэрээр хүн бүрт хүргүүлэх/		1	1	880,000	880,000	880,000
8	Зорилтот сумдад жендэрийн асуудалд хэрхэн анхаарч байгааг үнэлэх уулзалт, сургалт зохион байгуулах /шатахууны зардлыг тусад нь оруулсан/		1	1	860,000	860,000	860,000
9	8 дахь үйл ажиллагаатай холбоотой шатахууны зардал		1	1	250,000	250,000	250,000
Нийт дүн							5,190,000